



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/91

Жаргалтхаан

**Газар эзэмшүүлэх төсөл сонгон
шалгаруулалт зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтууд, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн Арваннаймдугаар хуралдааны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлтээр тусгагдсан малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх 10 нэгж талбар, 47 га газрын байршил, хэмжээ, зориулалт, газар эзэмшүүлэх хугацааг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Холбогдох хууль тогтоомжид заасны хүрээнд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг газрын биржийн цахим системээр зохион байгуулж, төслийн бичиг баримтыг 2024 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 15⁰⁰ цаг хүртэлх хугацаанд хүлээн авч ажиллахыг сумын газрын даамал (Н.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (С.Мөнхдэлгэр)-д даалгасугай.

ДАРГА

Л.ЦЭНГЭЛ

Сумын Засаг даргын 2024 оны 06 сарын
15-ны өдрийн 1/97 дугаар захирамжийн
...7 дүгээр хавсралт

Малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар
эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт,
зохион байгуулагдах хугацаа

д/д	Төлөвлөлтийн нэгж талбарын тугаар	Газрын байршил	Талбайн хэмжээ /га/	Зориулалт	Эзэмшүүлэх хугацаа /жил/
1	4112520	4-р баг Чулуут, 93га – 19	5,0	1624: Мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах	15
2	4112521	4-р баг Чулуут, 93га – 18	5,0		15
3	4112522	4-р баг Чулуут, 93га – 17	5,0		15
4	4112523	4-р баг Чулуут, 93га – 16	5,0		15
5	4112524	4-р баг Чулуут, 93га - 15	5,0		15
6	4112528	4-р баг Чулуут, 93га – 01	5,0		15
7	4112529	4-р баг Чулуут, 93га – 02	5,0		15
8	4112530	4-р баг Чулуут, 93га – 03	5,0		15
9	4112531	4-р баг Чулуут, 93га – 04	5,0		15
10	4112539	5-р баг Төвийн, Байц хороолол	2,0	1623: Мал аж ахуйн үйлдвэрлэл	15
ДҮН			47,0		